



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/365

Мандалговь

"Математик" хөтөлбөрийг амжилттай
хэрэгжүүлсэн багш Д.Бямбасүрэнг
урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.4, аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 28 өдрийн А/536 дугаар захирамжаар батлагдсан "Математик хөтөлбөр"-ийн 5.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018-2019 оны хичээлийн жилд аймгийн "Математик" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэсэн сурагчдын онооны дундаж үзүүлэлтээр шалгарсан "Цэгц билиг" сургуулийн математикийн багш Д.Бямбасүрэнг 1.000.000 төгрөгөөр урамшуулсугай.

Хоёр. Урамшууллын зардалд шаардагдах 1.024.000 (нэг сая хорин дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191020

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 04-ний өдрийн 1365 дугаар
захирамжийн хавсралт



ШИЛДЭГ БАГШ УРАМШУУЛАХ, УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Мөнгөн урамшуулал	1 удаа	1000000	1000000
2	Өргөмжлөл	1	18000	18000
3	Батламж	1	6000	6000
	ДҮН			1024000